



## НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/126

Улаанбаатар хот

“Хүнс хангамж төв” орон нутгийн  
өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын  
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7 дугаар хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 10 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 1,744,600.00 (нэг сая долоон зуун дөчин дөрвөн мянга зургаан зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ (Д.Идэрзаяа)-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй 7 нэр төрлийн нийт 1,744,600.00 (нэг сая долоон зуун дөчин дөрвөн мянга зургаан зуу) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг “Хүнс хангамж төв” ОНӨААТҮГ (Д.Идэрзаяа)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В. Оюумаа* В.ОЮУМАА





